



# ВАКЦИН, ЭСРЭГ ИЙЛДЭС



## БИОКОМБИНАТ ТӨХХК

---

Биокомбинат нь төрийн өмчит хариуцлагатай хувьцаат компани бөгөөд мал эмнэлгийн зориулалт бүхий вакцин, оношлуур зэрэг биобэлдмэл үйлдвэрлэдэг биотехнологийн үндэсний ууган үйлдвэр юм.

## ЗОРИЛГО

---

Технологийн шинэчлэлт, өндөр чанар, эрүүл мал

## ЗОРИЛТ

---

Шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийн нэг болох биотехнологийн зарчимд тулгуурлан орчин үеийн шаардлагад нийцүүлэн брилга байгууламж, дэвшилтэт технологи, мэргэжлийн чадварлаг хамт олны бүрэлдэхүүнтэйгээр өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Монгол улсын мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тодорхой хувь нэмрээ оруулах.



# ТҮҮХИЙН ХУУДАС

# БИОКОМБИНАТ ТӨХХК

1923 он



«Үхрийн мялзанг эсэргүүцэх станц» нэртэйгээр Биокомбинат ТӨААТҮГ-ын суурь тавигдсан.

1973 он

БНУУ-ын техник, эдийн засгийн тусламжтайгаар бүрэн шинэчлэгдсэн.



2024 он

Дараах 2 төслийг амжилттай хэрэгжүүлж үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

1. Дэлхийн банкны LCP төслийн санхүүжилт, дэмжлэгээр "Шугаман эсийн төсөл" хэрэгжүүлэлт 210 м<sup>2</sup> Үйлдвэрлэлийн байрыг GMP шаардлагад нийцүүлэн засварлаж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрэн шинэчлэл хийж, мэргэжилтнүүдийг шугаман эсийн технологит сургав.
2. Компанийн өөрийн хөрөнгө оруулалтаар "Автомат савлагааны төсөл" хэрэгжүүлж 700 м<sup>2</sup> үйлдвэрлэлийн байрыг GMP шаардлагад нийцүүлэн засварлаж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг иж бүрэн шинэчиллээ.

Нийт 230 гаруй ажилтан, мэргэжилтнүүдээс бүрдсэн 4 алба, 17 цех, нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Жилдээ 50 сая орчим тун биобэлдмэл үйлдвэрлэдэг.

Нийт 40 гаруй нэр төрлийн биобэлдмэл үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг 100% импорт орлох бүтээгдэхүүнээр хангаж байна.

Манай бүтээгдэхүүн нь Монгол орны бүх аймаг, сум, багт хүрч хэрэглэгддэг.



# ГАРЧИГ

- 01 BRUCELLA ABORTUS 19-р ОМГИЙН ВАКЦИН
- 02 BRUCELLA MELITENSIS REV-1 ОМГИЙН ВАКЦИН
- 03 BACILLUS ANTHRACIS "STERNE" ОМГИЙН ВАКЦИН
- 04 ҮХРИЙГ ДУУТ ХАВДАР ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 05 ХОНЬ, ЯМААГ ДОТРЫН ХАЛДВАРТ ХОРДЛОГО ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ХОС ЦЭНЭТ ВАКЦИН
- 06 ХОНЬ, ЯМААГ ДОТРЫН ХАЛДВАРТ ХОРДЛОГО, ЭНТЕРОБАКТЕРИОЗООС СЭРГИЙЛЭХ ХАМ ВАКЦИН
- 07 ХОНЬ, ЯМААГ КОЛИБАКТЕРИОЗ, ИЖ БАЛНАД ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 08 ЦУСАН ХАЛДВАР ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 09 ГАХАЙГ ЦУСАН ХАЛДВАР, ИЖ БАЛНАД ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 10 ШУВУУГ ЦУСАН ХАЛДВАР ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 11 ГАХАЙГ ЁЛОМ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 12 ТУГАЛЫГ ИЖ БАЛНАД ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 13 БОГ МАЛЫГ ЛИСТЕРИОЗООС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 14 МАЛ АМЬТНЫГ ГАЛЗУУ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН
- 15 ГАХАЙГ МЯЛЗАН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН
- 16 БОГ МАЛЫГ ШӨВӨГ ЯР ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН
- 17 ШУВУУГ ТАХАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН
- 18 ХОНИЙГ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН
- 19 АДУУ, ТЭМЭЭГ ТОМУУ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 20 ХОНЬ, ЯМААГ СОХОР ДОГОЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 21 ЯМААГ ГОДРОН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН
- 22 САХУУГААС СЭРГИЙЛЭХ БАКТЕРИН
- 23 КОЛИБАКТЕРИОЗЫН ЭСРЭГ ИЙЛДЭС
- 24 ЭНТЕРОБАКТЕРИОЗЫН ЭСРЭГ ИЙЛДЭС
- 25 ДОТРЫН ХАЛДВАРТ ХОРДЛОГЫН ЭСРЭГ ИЙЛДЭС
- 26 ЦУСАН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ИЙЛДЭС
- 27 БООМЫН ЭСРЭГ ИЙЛДЭС

- **Олон улсын нэр:** BRUCELLA ABORTUS STRAIN 19 VACCINE
- **Тодорхойлолт:** *Brucella abortus* 19-р омгийн вакцин нь бруцеллёзын үүсгэгчийн хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй *Brucella abortus* 19-р омгийг сонгомол аргаар өсгөвөрлөн лиофилизацийн технологиор хуурайшуулж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Brucella abortus* 19-р омгийн эсрэгтөрөгч, тусгай найрлага бүхий хамгаалан тогтворжуулагч орчин агуулна. Үлдэгдэл чийг 5%-аас ихгүй байна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар шаргал өнгийн хуурай нунтаг
- **Зориулалт:** Үхэрт бруцеллын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** 3-6 сарын настай охин тугалыг вакцинжуулна. Шаардлагатай тохиолдолд бухнаас бусад үхэр сүргийг нас, хүйс харгалзахгүйгээр *Brucella abortus* 19-р омгийн вакцинаар вакцинжуулж болно.
- **Тун:** *Brucella abortus* 19-р омгийн амьд вакцины 1 тун нь  $8-12 \times 10^9$  колони үүсгэх нэгж (КҮН) агуулна.
- **Олгох зам:** Үхрийн хүзүүний дунд хэсгийн буюу далны урд хэсгийн арьсан дор тарьж олгоно.

- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** 3-6 сартай охин тугалыг стандарт тунгаар нэг удаа вакцинжуулахад урт хугацааны найдвартай дархлаа тогтоно. *Brucella abortus* 19-р омгийн амьд вакцины багасгасан тунг бүх насны үхэрт арьсан дор тарьж олгосноос 2 долоо хоногийн дараа дархлааны хариу урвал бүрэн цогцлох ба энэхүү дархлаа нь 1 жилийн турш бруцеллын халдвараас найдвартай хамгаална.
- **Шингэлэх арга:** Энэхүү вакцины 1 тунг 2 мл 0,85%-ийн натрийн хлоридын уусмал буюу физиологийн уусмалаар шингэлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, вакцинжуулсан амьтан буюу үхэрт аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг  $+4^{\circ}\text{C}$ -аас  $+10^{\circ}\text{C}$ -ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 001 QL



- **Олон улсын нэр:** BRUCELLA MELITENSIS STRAIN REV-1 VACCINE
- **Тодорхойлолт:** *Brucella melitensis* REV-1 омгийн вакцин нь бруцеллэзын үүсгэгчийн хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй *Brucella melitensis* REV-1 омгийг сонгомол аргаар өсгөвөрлөн лиофилизацийн технологиор хуурайшуулж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Br. melitensis* Rev-1 омгийн эсрэгтөрөгч, хамгаалан-тогтворжуулагч орчин агуулна. Үлдэгдэл чийг нь 5%-аас ихгүй байна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар шаргал өнгийн хуурай нунтаг
- **Зориулалт:** Хонь, ямааг бруцеллын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халдварын эрсдэлтэй бүс нутгийн 3-6 сарын настай охин хурга, ишгийг вакцинжуулна. Шаардлагатай тохиолдолд хонь, ямааг нас, хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна. **Тус вакцинаар бог малыг хээлтүүлэхээс 1-2 сарын өмнө буюу намар 8-9 сард вакцинжуулвал зохино.**
- **Тун:** *Brucella melitensis* REV-1 омгийн амьд вакцины 1 тун нь  $8 \times 10^8 - 1,2 \times 10^9$  колони үүсгэх нэгж (КУН) агуулна.
- **Олгох зам:** Хурга, ишигний далны өмнөх эсвэл цавины арьсан дор тарьж олгоно. Мөн хурга, ишигний нүдний зовхинд дусааж олгож болно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** 3-6 сарын настай охин хурга, ишгийг стандарт тунгаар нэг удаа вакцинжуулахад урт хугацааны найдвартай дархлаа тогтоно. Энэхүү амьд вакцинаар вакцинжуулснаас 14 хоногийн дараа дархлааны хариу урвал бүрэн цогцолж 2-3 жилийн турш бруцеллын халдвараас найдвартай хамгаална.
- **Шингэлэх арга:** Энэхүү вакцины 1 тунг 1 мл 0,85%-ийн натрийн хлоридийн уусмал буюу физиологийн уусмалаар шингэлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг  $+4^{\circ}\text{C}$ -аас  $+10^{\circ}\text{C}$ -ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 002 QL





# 04 ҮХРИЙГ ДУУТ ХАВДАР ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН

- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST BLACKLEG IN CATTLE
- **Тодорхойлолт:** Дуут хавдраас сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь тухайн халдварт өвчний үүсгэгч *Clostridium chauvoei*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг анаэроб нөхцөлд ферментацийн аргаар өсгөвөрлөж, формальдегидээр идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гельтэй хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Clostridium chauvoei*-ийн гаралтай экзотоксин, эндотоксин, идэвхгүйжсэн эс, хөнгөн цагааны усан ислийн гель  $Al(OH)_3$ , идэвхгүйжүүлэгч бодис агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Бор шаргал буюу бор саарал өнгийн шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад доод хэсэгт нь бор саарал өнгийн сөвсгэр тунадас тунаж дээд хэсэгт нь тунгалаг шаргал шингэн ялгарна. Лонхтой вакциныг сэгсрэхэд тунадас нь задарч нэгэн жигд бор шаргал буюу бор саарал цийдмэг болно.
- **Зориулалт:** Дуут хавдар өвчний үүсгэгч *Cl.chauvoei*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Таваас доош насны бүх үхрийг хүйс харгалзахгүй вакцинжуулна. Гэхдээ уг халдварт өвчний голомттой бүс нутгийн бүх насны үхрийг вакцинжуулж болно.
- **Тун:** Тугал, бярууг 3 мл, нас гүйцсэн үхрийг 5 мл тунгаар вакцинжуулна.

- **Олгох зам:** Үхрийн хүзүүний арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Үхэрт энэхүү вакцины зохистой тунг олгосноос 14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь үхрийг *Clostridium chauvoei*-ийн халдвараас 6 сар найдвартай хамгаална.  
**Тайлбар:** Үхрийг энэхүү вакцинаар анх удаа вакцинжуулах үед 14-21 хоногийн зайтай 2 удаа анхдагч ба хоёрдогч тунг олгох нь илүү өндөр хүчдэлтэй, удаан хугацаанд үргэлжлэх идэвхтэй дархлаа тогтоох шинжлэх ухааны үндэслэлтэй.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 18 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 006 QL



# 05

## ХОНЬ, ЯМААГ ДОТРЫН ХАЛДВАРТ ХОРДЛОГО ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ХОС ЦЭНЭТ ВАКЦИН

- **Олон улсын нэр:** BIVALENT VACCINE AGAINST ENTEROTOXAEMIA IN SHEEP AND GOATS
- **Тодорхойлолт:** Хонь, ямааг дотрын халдварт хордлогоос сэргийлэх хос цэнэт вакцин нь тухайн халдварт өвчнийг үүсгэгч *Clostridium perfringens*-ийн C, D хэвшлийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гелтэй хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Clostridium perfringens*-ийн C хэвшлийн бета (β) хор, D хэвшлийн эпсилон (ε) хор, идэвхгүйжсэн эс, хөнгөн цагааны усан ислийн гел  $Al(OH)_3$ , идэвхгүйжүүлэгч бодис агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Бор шаргал буюу цайвар шаргал өнгийн шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад доод хэсэгт нь цайвар бор өнгөтэй сэвсгэр тунадас тунаж дээд хэсэгт нь тунгалаг шаргал шингэн ялгарах ба сэгсрэхэд тунадас нь задарч нэгэн жигдийн булингартай цийдмэг болно.
- **Зориулалт:** Хонь, ямааг *Cl.perfringens*-ийн C ба D хэвшлийн халдвараас хамгаалах зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Хонь, ямааг нас, хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна.

- **Тун:** 6 сар хүртэлх насны хурга, ишгэнд анхдагч тун 1 мл, хоёрдогч тун 1,5 мл, хонь ямаанд анхдагч тун 2 мл, хоёрдогч тун 3 мл байна. Вакцины анхдагч тунг олгосноос 14-16 хоногийн дараа хоёрдогч тунг олгоно.
- **Олгох зам:** Гуяны дотор талын арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг олгосноос 14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь *Cl.perfringens*-ийн C, D хэвшлийн халдвараас 4-6 сар найдвартай хамгаална.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, вакцинжуулсан мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 007 QL



# 06 ХОНЬ, ЯМААГ ДОТРЫН ХАЛДВАРТ ХОРДЛОГО, ЭНТЕРОБАКТЕРИОЗООС СЭРГИЙЛЭХ ХАМ ВАКЦИН

- **Олон улсын нэр:** COMBINED VACCINE AGAINST ENTEROTOXAEMIA AND ENTEROBACTERIOSIS IN SHEEP AND GOATS
- **Тодорхойлолт:** Хонь, ямааг дотрын халдварт хордлого, энтеробактериозоос сэргийлэх хам вакцин нь тухайн халдварт өвчнийг үүсгэгч *Clostridium perfringens*-ийн C, D хэвшил болон *Escherichia coli*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гелтэй хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Clostridium perfringens*-ийн C хэвшлийн бета (β) хор, D хэвшлийн эпсилон (ε) хор болон *Escherichia coli*-ийн экзо, эндотоксин, идэвхгүйжсэн эс, хөнгөн цагааны усан ислийн гель  $Al(OH)_3$ , идэвхгүйжүүлэгч бодис агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар шаргал буюу бор шаргал өнгөтэй шингэн. Вакциныг Хөдөлгөөнгүй байлгахад доод хэсэгт нь бор саарал өнгөтэй тунадас тунаж, дээд хэсэгт нь цайвар шаргал өнгөтэй ялимгүй булингартай шингэн ялгарах ба сэгсрэхэд тунадас нь задарч нэгэн жигд цийдмэг болно.
- **Зориулалт:** Бог малд *Cl.perfringens*-ийн C,D хэвшлийн болон *E.coli*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** 3 сараас дээш насны бүх хонь, ямааг хүйс үл харгалзан вакцинжуулна.
- **Тун:** 3-10 сарын настай хурга, ишгэнд анхдагч тун 2 мл, хоёрдогч тун 3 мл, хонь ямаанд анхдагч тун 3 мл, хоёрдогч тун 4 мл байна. Вакцины анхдагч тунг олгосноос 14-16 хоногийн дараа хоёрдогч тунг олгоно.
- **Олгох зам:** Далны урд хэсгийн арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг олгосноос 15 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь *Cl.perfringens*-ийн C, D хэвшил болон *E.coli*-ийн халдвараас 4-6 сар найдвартай хамгаална.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, вакцинжуулсан мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 008 QL



- **Олон улсын нэр:** COMBINED VACCINE AGAINST COLIBACTERIOSIS AND SALMONELLOSIS IN SHEEP AND GOATS
- **Тодорхойлолт:** Колибактериоз, иж балнад өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь тухайн халдварт өвчнүүдийг үүсгэгч *Escherichia coli* болон *Salmonella*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гельтэй хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Escherichia coli* болон *Salmonella*-ийн омгуудын эсрэгтөрөгч, хөнгөн цагааны усан ислийн гель /Al(OH)<sub>3</sub>/, идэвхгүйжүүлэгч бодис агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Хүрэн болон бор шаргал өнгөтэй шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад доод хэсэгт цайвар шаравтар өнгөтэй тунадас тунаж, дээд хэсэгт нь тунгалаг шаргал шингэн ялгарна. Сэгрэхэд тунадас нь задарч нэгэн жигд цийдмэг болно.
- **Зориулалт:** Хонь, ямаанд *Salmonella* болон *E.coli*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Мал төллөхөөс 30-45 хоногийн өмнө хээлтэй эх малыг 14-15 хоногийн завсарлагатайгаар 2 удаа вакцинжуулна.
- **Тун:** Хонь, ямаанд анхдагч тунг 3 мл, хоёрдогч тунг 5 мл-ээр олгоно.
- **Олгох зам:** Хүзүүний дунд хэсгийн арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины анхдагч тунг олгосноос 2 долоо хоногийн дараа вакцинжуулсан мал амьтны биемахбодид идэвхтэй дархлаа үүсэж, улмаар хоёрдогч тунг олгосноор уг дархлаа батжина. Энэхүү дархлаа нь хонь, ямааг *Salmonella* болон *E.coli*-ийн халдвараас 6 сарын турш найдвартай хамгаална.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Ямар нэгэн эсрэг заалт тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 010 QL



# 08 ЦУСАН ХАЛДВАР ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН

- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST HAEMORRHAGIC SEPTICAEMIA IN CATTLE, SHEEP AND GOATS
- **Тодорхойлолт:** Цусан халдвар өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь энэхүү халдварт өвчний үүсгэгч *Pasteurella multocida*-ийн эсрэгтөрүүлэгч чанар өндөртэй, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөн формальдегидаар идэвхгүйжүүлж хөнгөн цагааны усан ислийн гелтэй хольж бэлтгэдэг өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Pas.multocida*-ийн эсрэгтөрөгч, хөнгөн цагааны усан ислийн гель  $Al(OH)_3$ , идэвхгүйжүүлэгч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Бор шаргалаас хулсан шаргал өнгөтэй шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад ёроолдоо цайвар саарал өнгийн тунадастай, дээд хэсэгт нь ялимгүй бүүсгэр бүүсгэр шингэн ялгарах сэгсрэхэд тунадас нь задарч холилдон нэгэн жигд булингартай шингэн болно.
- **Зориулалт:** Мал, амьтанд *Pas.multocida*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** *Pas.multocida*-ийн халдварын эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтдыг нас, хүйс үл харгалзан вакцинжуулна.
- **Тун:** Үхэрт анхдагч тун 5 мл, хоёрдогч тун 10 мл, бог малд анхдагч тун 5 мл, хоёрдогч тун 8 мл, тугал, хурга, ишгэнд анхдагч тун 3 мл, хоёрдогч тун 5 мл-ээр олгоно.
- **Олгох зам:** Үхрийн хүзүүний, хонь, ямааны цавины арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины анхдагч болон хоёрдогч тунг 14 хоногийн завсарлагатайгаар олгосноос 7 хоногийн дараа цусан халдварын эсрэг идэвхтэй дархлаа үүснэ. Энэхүү дархлаа нь *P.multocida*-ийн халдвараас 6 сарын турш найдвартай хамгаална.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй
- **Хадгалалт:** Энэхүү вакциныг  $+4^{\circ}C$ -аас  $+10^{\circ}C$ -ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 011 QL



- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST HAEMORRHAGIC SEPTICAEMIA AND SALMONELLOSIS IN PIG
- **Тодорхойлолт:** Гахайг цусан халдвар, иж балнад өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь эдгээр халдварт өвчнүүдийг үүсгэгч *Pasteurella multocida*, *Salmonella suis*, *Salmonella typhimurium*-ийн эсрэгтөрүүлэгч чанар өндөртэй, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөн формальдегидаар идэвхгүйжүүлж хөнгөн цагааны усан ислийн гелтэй хольж бэлтгэдэг өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Pas.multocida*, *Sal.suis*, *Sal.typhimurium*-ийн эсрэгтөрөгч, хөнгөн цагааны усан ислийн гел / Al(OH)<sub>3</sub>/, идэвхгүйжүүлэгч бодис агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар шаргалаас бор шаргал өнгийн шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад доод хэсэгт нь бор саарал өнгөтэй сэвсгэр тунадас тунаж, дээд хэсэгт нь цайвар шаргал өнгөтэй ялимгүй булингартай шингэн ялгарна. Сэгсрэхэд тунадас нь задарч нэгэн жигд булингартай цийдмэг болно.
- **Зориулалт:** *Pasteurella multocida* болон *Salmonella*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Гахайг нас, хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна.

- **Тун:** Гахайд анхдагч тун 5 мл, хоёрдогч тун 8 мл, торойд анхдагч тун 3-4 мл, хоёрдогч тун 4-5 мл байна. Анх удаа вакцинжуулж буй гахайд 14 хоногийн зайтай анхдагч болон хоёрдогч тунг олгоно. Харин өмнө нь вакцинжуулж байсан гахайд 6 сар тутамд зөвхөн хоёрдогч тунг олгоход дархлаа сайн тогтоно.
- **Олгох зам:** Гахайны гуяны дотор талын буюу хүзүүний арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины анхдагч ба хоёрдогч тунг 10-14 хоногийн зайтайгаар олгосноос 7-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүснэ. Энэхүү дархлаа нь гахайг *Pasteurella multocida* болон *Salmonella*-ийн халдвараас 6 сарын турш хамгаална.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 012 QL



- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST PASTEURELLOSIS IN POULTRY
- **Тодорхойлолт:** Цусан халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь энэхүү халдварт өвчинг үүсгэгч *Pasteurella multocida*-ийн эсрэгтөрүүлэгч чанар өндөртэй, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөн формальдегидаар идэвхгүйжүүлж, хөнгөн цагааны усан ислийн гелтэй хольж бэлтгэдэг өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Pas. multocida*-ийн ВК-3 омгийн эсрэгтөрөгч, хөнгөн цагааны усан ислийн гель/ $Al(OH)_3$ /, идэвхгүйжүүлэгч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Шаргалаас хүрэн шар өнгөтэй шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад ёроолдоо цайвар бор өнгийн тунадас сууж, дээд хэсэгт нь ялимгүй бүүсгэр шингэн ялгарна. Сэгсрэхэд тунадас нь задарч холилдон нэгэн жигд булингартай шингэн болно.
- **Зориулалт:** Шувууг *Pasteurella multocida*-ийн халдвараас сэргийлэх идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Гэрийн тэжээвэр бүх төрлийн шувууг нас, хүйс үл харгалзан вакцинжуулна.
- **Тун:** Дэгдээхийг 1-3 мл, тахиа, нугасыг 3 мл, галуу, цацагт хяруулыг 5-6 мл тунгаар вакцинжуулна.
- **Олгох зам:** Шувууны эгэм, хүзүүний арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг олгосноос 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь шувууг *Pas. multocida*-ийн халдвараас 3 сарын турш хамгаална.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг  $+4^{\circ}C$ -аас  $+10^{\circ}C$ -ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 013 QL



- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST SWINE ERYSIPELAS
- **Тодорхойлолт:** Гахайг ёлом өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь уг халдварт өвчний үүсгэгч *Erysipelothrix rhusiopathiae*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гелтэй хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Erysipelothrix rhusiopathiae*-ийн омгийн эсрэгтөрөгч, адьювант, идэвхгүйжүүлэгч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Хүрэн буюу бор шаргал өнгийн шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад доод хэсэгт нь цайвар бор өнгөтэй сэвсгэр тунадас тунаж, дээд хэсэгт нь шаргал өнгөтэй тунгалаг шингэн ялгарах ба сэгсрэхэд тунадас нь задарч нэгэн жигд цийдмэг болно.
- **Зориулалт:** Гахайд *Erysipelothrix rhusiopathiae*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Ёлом өвчнөөр тайван бус аж ахуйд 2 сараас дээш настай гахайг нас, хүйс үл харгалзан вакцинжуулна. Харин уг өвчнөөр тайван бүс нутаг, аж ахуйд урьдчилан сэргийлэх зорилгоор 2-15 сарын настай буюу халдварт өртөмтгий насны гахайг түүвэрлэн вакцинжуулж болно.

- **Тун:** Гахайд олгох тун нь биеийн жингээс хамаарна. 80 кг хүртэлх амьтдын жинтэй гахайг 5 мл, 80 кг-аас дээш амьтдын жинтэй гахайг 10 мл тунгаар вакцинжуулна.
- **Олгох зам:** Чихний арын буюу гуяны дотор талын арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг 1 удаа олгоод 2-3 долоо хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь гахайг *Erysipelothrix rhusiopathiae*-ийн халдвараас 4 сарын турш хамгаална.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 014 QL



# 12 ТУГАЛЫГ ИЖ БАЛНАД ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН

- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST SALMONELLOSIS IN CALVES
- **Тодорхойлолт:** Тугалыг иж балнад өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь уг халдварт өвчний үүсгэгч *Salmonella*-ийн Гертнерийн бүлгийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гелтэй хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Salmonella*-ийн омгуудын эсрэгтөрөгч, адьювант, идэвхгүйжүүлэгч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар бор болон бор шаргал өнгөтэй шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад доод хэсэгт нь цайвар бор өнгийн сэвсгэр тунадас тунаж, дээд хэсэгт нь ялимгүй булингартай шингэн ялгарах ба сэгсрэхэд тунадас нь задарч нэгэн жигд цийдмэг болно.
- **Зориулалт:** Үхэрт *Salmonella*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Хээлтэй үнээ болон 2 сараас доош настай тугалыг энэхүү вакцинаар вакцинжуулна. Вакциныг хээлтэй үнээнд тугаллахаас нь 30-45 хоногийн өмнө 8-10 хоногийн зайтай 2 удаа олгоно. 3-5 хоногийн настай тугалд 3-5 хоногийн зайтай 2 удаа, 5-60 хоногийн настай тугалд 1 удаа тарьж олгоно.
- **Тун:** 3-5 хоногийн настай тугалд анхдагч тун 0,1-0,5 мл, хоёрдогч тун 0,5-0,75 мл, 50-60 хоногийн настай тугалд 0,75 мл, хээлтэй үнээнд анхдагч тун 5 мл, хоёрдогч тун 7,5 мл байна.
- **Олгох зам:** Хүзүүний арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины хоёрдогч тунг олгосноос 10 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэж энэхүү дархлаа нь *Salmonella*-ийн халдвараас 5 сарын турш хамгаална.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 015 QL



# 13

## БОГ МАЛЫГ ЛИСТЕРИОЗООС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН

- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST LISTERIOSIS IN SHEEP AND GOATS
- **Тодорхойлолт:** Листерриоз өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь уг халдварт өвчний үүсгэгч *Listeria monocytogenes*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гелтэй хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Listeria monocytogenes*-ийн I-II, V хэвшлийн омгуудын эсрэгтөрөгч, адьювант, идэвхгүйжүүлэгч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Хүрэн болон бор шаргал өнгийн шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй удаан байлгахад доод талд нь цайвар бор өнгөтэй тунадас тунаж, дээд хэсэгт нь шаргал өнгөтэй тунгалаг шингэн ялгарах ба сэгсрэхэд тунадас нь амархан задарч нэгэн жигд цийдмэг болно.
- **Зориулалт:** Бог малд *Listeria monocytogenes*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Гурван сараас дээш насны бүх хонь, ямааг хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна.

- **Тун:** 3-12 сарын настай хурга, ишгэнд анхдагч тун 2,5 мл, хоёрдогч тун 2,5 мл, хонь, ямаанд анхдагч тун 5 мл, хоёрдогч тун 5 мл байна.
- **Олгох зам:** Хүзүүний арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Хонь, ямаанд энэхүү вакцины анхдагч ба хоёрдогч тунг олгосноос 1-2 долоо хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 6 сарын турш листериозоос урьдчилан сэргийлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 016 QL



# 14 МАЛ АМЬТНЫГ ГАЛЗУУ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН

- **Олон улсын нэр:** LIVE VACCINE AGAINST RABIES (PRIMARY CELL CULTURE)
- **Тодорхойлолт:** Мал амьтныг галзуу өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Rabdoviridae* язгуурын *Lissavirus* төрөлд хамаарах РНХ агуулсан вирусын хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг торойны бөөрний эсийн өсгөвөрт өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** Галзуу өвчний вирусын хоруу чанарыг нь сулруулсан ERA омгийн эсрэгтөрөгч, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалагч орчин агуулна. Үлдэгдэл чийг 5%-иас ихгүй байна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цагаан шаргал өнгийн хуурай нунтаг
- **Зориулалт:** Мал, амьтанд галзуугийн үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Гэрийн бүх төрлийн тэжээвэр мал, амьтдыг нас хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна.
- **Тун:** Адуу, үхэр, хонь, ямаа, нохой, муурыг 1 тун буюу 2 мл-ээр вакцинжуулна.
- **Олгох зам:** Гуяны булчинд тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Мал, амьтдад вакцины зохистой тунг олгосноос 3-4 долоо хоногийн дараа идэвхтэй дархлаа тогтох ба энэхүү дархлаа нь галзуугаас 1 жилийн турш хамгаална. Вакцинжуулсан эх мал, эх амьтнаас гарсан төл эхний 4 сар дархлаатай байна. Иймд унага, тугал, хурга, ишгийг 4-6 сарын настайд нь, гөлөг, муурын зулзагыг 3-4 сарын настайд нь вакцинжуулна.
- **Шингэлэх арга:** Вакцины 1 тунг 2 мл 0,85%-ийн натрийн хлоридын уусмал буюу физиологийн уусмалаар шингэлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, вакцинжуулсан мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг -15°C-ээс -20°C-ийн харанхуй, хуурай орчид хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 017 QL



# 15 ГАХАЙГ МЯЛЗАН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН

- **Олон улсын нэр:** LIVE VACCINE AGAINST CLASSICAL SWINE FEVER
- **Тодорхойлолт:** Гахайг мялзан өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Flaviviridae* язгуурын *Pestivirus* төрөлд хамаарах РНХ агуулсан вирусын хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг туулайд халдварлуулан өсгөвөрлөөд ялган авч, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Flaviviridae* язгуурын *Pestivirus* төрөлд хамаарах вирусын Сувак омгийн эсрэгтөрөгч, тогтворжуулан хамгаалах орчин агуулна. Үлдэгдэл чийг 5%-аас ихгүй байна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Улаавтар, улаавтар хүрэн өнгийн тодорхой хэлбэр дүрсгүй сэвсгэр хуурай нунтаг
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** 2 сараас дээш насны гахайг хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна.
- **Зориулалт:** Гахайд мялзангийн вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Тун:** Гахайг 1 тун буюу 2 мл-ээр вакцинжуулна.

- **Олгох зам:** Хүзүүний булчинд тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг олгосноос 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 1 жилийн турш мялзангаас сэргийлнэ.
- **Шингэлэх арга:** Вакцины 1 тунг 2 мл фосфат бамбайн уусмалаар шингэлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд үйлдвэрлэсэн өдрөөс хойш 6 сар хүртэл хүчинтэй. Хэрэв вакциныг -15°C-ээс -20°C-ийн харанхуй хуурай байранд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 020 QL



- **Олон улсын нэр:** LIVE VACCINE AGAINST CONTAGIOUS ECTHYMA IN SHEEP AND GOATS (ANIMAL PASSAGE)
- **Тодорхойлолт:** Шөвөг яр өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Poxviridae* язгуурын *Parapoxivirus* төрөлд хамаарах ДНХ агуулсан вирусын хордуу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг ямааны арьсанд халдварлуулан өсгөвөрлөөд ялган авч, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Poxviridae* язгуурын *Parapoxivirus* төрөлд хамаарах ХД-60 омгийн эсрэгтөрөгч, тогтворжуулан хамгаалах орчин агуулна. Үлдэгдэл чийг 5%-аас ихгүй байна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цагаан шаргал, шаргал өнгийн тодорхой хэлбэр дүрсгүй сэвсгэр хуурай нунтаг
- **Зориулалт:** Хурга, ишгэнд шөвөг ярын вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** 14 хүртэлх хоногийн настай хурга, ишгийг вакцинжуулна.
- **Тун:** 1 тун буюу 0,2 мл-ээр вакцинжуулна.
- **Олгох зам:** Хурга, ишигний дээд уруулын арьсыг цус гаргахгүй зурж арьсны өнгөн хэсэгт зураас үүсгээд уг зураасан дээр вакцины зохих тунг түрхэж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг олгосноос 10-15 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 5-6 сар тогтвортой хадгалагдана.
- **Шингэлэх арга:** Вакцины 1 тунг 0,2 мл 50%-ийн глицерины уусмалаар шингэлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй. Хэрэв вакциныг -15°C-ээс -20°C-ийн харанхуй хуурай байранд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 022 QL



- **Олон улсын нэр:** LIVE VACCINE AGAINST FOWL

- **Тодорхойлолт:** Шувууг тахал өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Orthomyxoviridae* язгуурын *Influenzavirus* төрөлд хамаарах PHX агуулсан вирусн хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллонтотс бүрхүүлд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.

- **Найрлага:** *Orthomyxoviridae* язгуурын *Influenzavirus* төрөлд хамаарах вирусн LaSota омгийн эсрэгтөрөгч, тогтворжуулан хамгаалах орчин агуулна. Үлдэгдэл чийг 5%-аас ихгүй байна.

- **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар шаргал, ягаавтар туяатай цайвар өнгийн тодорхой хэлбэр дүрсгүй сөвсгэр хуурай нунтаг

- **Зориулалт:** Шувуунд тахал өвчнийг үүсгэгч вирусн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай .

- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Тэжээвэр шувуудыг нас, хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна. Шувууны аж ахуйд шувууг эхлээд 3 удаа вакцинжуулаад цаашдаа 4 сар тутамд тогтмол вакцинжуулж байх шаардлагатай. Үүний тулд 10-14 хоногийн настай дэгдээхийд анхдагч тунг, 60 хоногийн настайд нь хоёрдогч тунг, 4-5 сарын настайд нь гуравдагч тунг олгоод улмаар 4 сар тутамд вакцинжуулна.

- **Тун:** 1 тун буюу 20 мл-ээр вакцинжуулна.

- **Олгох зам:** Ундны усанд уусгаж амаар олгоно.

- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины 1 тунг 20 мл ундны усанд нь уусгаж уулгах замаар олгосноос 10-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь шувууг 4 сарын турш тахалаас сэргийлнэ.

- **Шингэлэх арга:** 1 тунг 20 мл ундны усанд уусгаж шингэлнэ.

- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.

- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.

- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд үйлдвэрлэсэн өдрөөс хойш 3 сар хүчинтэй. Хэрэв -15°C-ээс -20°C-ийн харанхуй хуурай байранд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүчинтэй.

- **Бүртгэлийн дугаар:** 024 QL



# 18 ХОНИЙГ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АМЬД ВАКЦИН

- **Олон улсын нэр:** LIVE VACCINE AGAINST POX IN SHEEP (PRIMARY CELL CULTURE)
- **Тодорхойлолт:** Хонийг цэцэг өвчнөөс сэргийлэх амьд вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Poxviridae* язгуурын *Capripoxvirus* төрөлд хамаарах ДНХ агуулсан вирусын хоруу чанарыг нь сулруулсан, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг хурганы засааны анхдагч эсэд өсгөвөрлөж, тусгай найрлага бүхий тогтворжуулан-хамгаалах орчинтой зохих харьцаагаар хольж, лиофилизацийн аргаар хуурайшуулан бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Poxviridae* язгуурын *Capripoxvirus* төрөлд хамаарах вирусын Рогом омгийн эсрэгтөрөгч, тогтворжуулан хамгаалах орчин агуулна. Үлдэгдэл чийг 5%-аас ихгүй байна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цагаан шаргал өнгийн сөвсгэр нунтаг
- **Зориулалт:** Хонинд цэцэг өвчнийг үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Хонийг нас, хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна. Хурганд 7 хоногийн настайд нь анхдагч тунг олгоод 3 сарын дараа хоёрдогч тунг зайлшгүй олгох шаардлагатай.
- **Тун:** Хонийг 1 тун буюу 1 мл-ээр, хургыг ½ тун буюу 0,5 мл-ээр вакцинжуулна.

- **Олгох зам:** Цавь, суганы арьсан дор тарина.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Хонинд цэцэг өвчнөөс сэргийлэх вакцины зохистой тунг олгосноос 8-14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 18 сарын турш цэцэг өвчний үүсгэгчийн халдвараас найдвартай хамгаална.
- **Шингэлэх арга:** 1 тунг 1 мл 0,85% натрийн хлорид /NaCl/-ын уусмал буюу физиологийн уусмалаар шингэлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 6 сар хүртэл хүчинтэй. Хэрэв -15°C-ээс -20°C-ийн харанхуй хуурай байранд хадгалвал үйлдвэрлэсэн өдрөөс хойш 18 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 025 QL



- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST INFLUENZA IN HORSES AND CAMELS
- **Тодорхойлолт:** Адуу, тэмээг томуу өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Orthomixoviridae* язгуурын *Influenza* төрлийн А хэвшилд хамаарах PHX агуулсан вируссын дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг тахианы үр хөврөлт өндөгний амнион-аллонтоис бүрхүүлд өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гельтэй тодорхой харьцаагаар хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Orthomixoviridae* язгуурын *Influenza* төрлийн А хэвшлийн вируссын эсрэгтөрөгч, адьювант, идэвхгүйжүүлэгч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Шаргалдуу цагаан өнгөтэй шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй удаан байлгахад доод хэсэгт нь цайвар саарал өнгийн сэвсгэр тунадас үүсэж, дээд хэсэгт нь ялимгүй булингартай шингэн ялгарах ба сэгсрэхэд тунадас задарч нэгэн жигд цэхэрдүү цагаан цийдмэг болно.
- **Зориулалт:** Адуу, тэмээг томуугийн үүсгэгч вирусын халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Адуу, тэмээг нас, хүйс харгалзахгүйгээр вакцинжуулна.

- **Тун:** Адууг 5 мл, тэмээг 10 мл тунгаар 1 удаа вакцинжуулна.
- **Олгох зам:** Хүзүүний дунд хэсгийн арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохистой тунг олгосноос 14-21 хоногийн дараа вакцинжуулсан амьтдын бие махбодид идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 6 сарын турш тогтвортой хадгалагдана.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 026 QL



# 20 ХОНЬ, ЯМААГ СОХОР ДОГОЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН ВАКЦИН

- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST CONTAGIOUS AGALACTIA IN SHEEP AND GOATS
- **Тодорхойлолт:** Сохор догол өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Mycoplasma agalactia*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй нутгийн омгуудыг шингэн тэжээлт орчинд ферментацийн аргаар өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гелтэй тодорхой харьцаагаар хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Mycoplasma agalactia*-ийн эсрэгтөрөгч, адьювант, идэвхгүйжүүлэгч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Цайвар шаргал өнгөтэй шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй удаан байлгахад доод хэсэгт нь цайвар саарал өнгөтэй тунадас тунаж, дээд хэсэгт нь ялимгүй булингартай цайвар шаргал өнгөтэй шингэн ялгарах ба сэгсэрч зайлахад тунадас нь задарч нэгэн жигд шингэн цийдмэг болно.
- **Зориулалт:** Хонь, ямааг сохор доголын үүсгэгч *Mycoplasma agalactia*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Хонь, ямааг нас, хүйс үл харгалзан вакцинжуулна.
- **Тун:** Хонь, ямааг 5 мл тунгаар, хурга, ишгийг 2 мл тунгаар 1 удаа вакцинжуулна.
- **Олгох зам:** Гуяны дотор талын арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Вакцины зохих тунг нь олгосноос 14 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 6 сарын турш сохор доголын үүсгэгчийн халдвараас сэргийлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 6 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 029 QL



- **Олон улсын нэр:** INACTIVATED VACCINE AGAINST CONTAGIOUS CAPRINE PLEUROPNEUMONIA IN GOATS
- **Тодорхойлолт:** Годрон өвчнөөс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Mycoplasma capricolium*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийг ямааны уушигны эдэд зорчуулан өсгөвөрлөж, формальдегидаар идэвхгүйжүүлэн хөнгөн цагааны усан ислийн гелтэй тодорхой харьцаагаар хольж бэлтгэдэг урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Mycoplasma capricolium*-ийн омгийн эсрэгтөрөгч, адьювант, идэвхгүйжүүлэгч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Бор шаргалаас хулсан шаргал өнгийн шингэн. Вакциныг хөдөлгөөнгүй байлгахад доод хэсэгт нь цайвар өнгөтэй, сэвсгэр тунадас тунах ба сэгсэрч зайлахад тунадас нь нэгэн жигд булингартай цийдмэг болно.
- **Зориулалт:** Ямааг *Mycoplasma capricolium*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох зориулалттай.
- **Вакцинжуулах амьтдын төрөл, нас, хүйс:** Хоёр сараас дээш насны ямааг хүйс үл харгалзан вакцинжуулна.
- **Тун:** 2-6 сарын настай ишгийг 3 мл тунгаар, 6 сараас дээш насны ямааг 6 мл тунгаар 1 удаа вакцинжуулна.
- **Олгох зам:** Хүзүү болон гуяны дотор талын арьсан дор тарьж олгоно.
- **Дархлааны үргэлжлэх хугацаа:** Ямаанд энэхүү вакцины зохистой тунг олгосноос 7-12 хоногийн дараа идэвхтэй дархлаа үүсэх ба энэхүү дархлаа нь 1 жилийн турш годрон өвчнөөс сэргийлнэ.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал, амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү вакциныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 6 сар хүртэл хүчинтэй.



# 22 САХУУГААС СЭРГИЙЛЭХ БАКТЕРИН

- **Олон улсын нэр:** BACTERIN FOR PREVENTIVE AND TREATMENT AGAINST STRANGLES IN HORSES
- **Тодорхойлолт:** Сахуугаас сэргийлэх бактерин нь уг халдварт өвчнийг үүсгэгч *Streptococcus equi*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй нутгийн омгуудыг шингэн тэжээлт орчинд *Streptococcus equi*-ийн өөрийнх нь үржил, хөгжлийг саатуулан зогсоох үйлчилгээтэй бодис (*antivirus*) үүстэл өсгөвөрлөөд карболын хүчлээр хадгалааслаж, Зейтцийн шүүрээр шүүж бэлтгэдэг өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Streptococcus equi*-ийн эсрэг бодис, хадгалааслагч агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Хулсан шаргал, хүрэн шаргал өнгийн тунгалаг шингэн
- **Зориулалт:** Адуунд *Streptococcus equi*-ийн халдвараас хамгаалах идэвхтэй дархлаа тогтоох болон сахуугаар өвчилсөн адууг эмчлэх зориулалттай.
- **Сэргийлэлт, эмчилгээнд хамрагдах амьтдын төрөл, нас, хүйс:** Бага насны адуу нь *Streptococcus equi*-ийн халдварлалтад илүү өртөмтгий. Гэвч өмнө нь сахуугаар өвчилж байгаагүй буюу өвчилж байсан ч дархлаа нь алдагдсан бүх насны адуу өвчилж болзошгүй. Иймд сэргийлэх болон эмчлэх зорилгоор бүх нас, хүйсийн адуунд зохих тунг олгоно.
- **Тунг:** Бактериныг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх тохиолдолд унага, даага, сарваанд 30-60 мл-ийг, эмчилгээний зорилгоор хэрэглэх тохиолдолд унага, даага, сарваанд 50-100 мл-ийг тус тус олгоно.
- **Олгох зам:** Урьдчилан сэргийлэх зорилгоор хүзүүг 3 хуваасны урд хэсгийн арьсан дор адууны амьдын жингээс хамааран сэргийлэх тунг 2-3 хэсэг газарт хувааж тарина. Харин сахуугаар өвчилсөн тохиолдолд идээлсэн, хавдсан буглааг хагалж угааж шавших, хөвөн самбайд шингээж боох, мөн буглааны эргэн тойронд эмчилгээний тунгаар арьсан дор тарина. Энэхүү эмчилгээ хийсэн адуу эдгэрэхгүй бол эмчилгээг 3-5 хоногийн зайтайгаар 2-3 удаа давтан хийж болно.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Бактериныг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хүчинтэй.
- **Бүртгэлийн дугаар:** 038 QL



- **Олон улсын нэр:** COLIBACTERIOSIS SERUM
- **Тодорхойлолт:** Колибактериозын эсрэг ийлдэс нь энэхүү халдварт өвчний үүсгэгч *Escherichia coli*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй нутгийн омгуудын өсгөврөөр бүтээхүүн малд хэт дархлаа хийж, цусан дах эсрэг биемийн төвшрүүлэг зохих хэмжээнд хүрэхэд цус авч, ийлдсийг нь ялган, хадгалааслаж бэлтгэдэг *Escherichia coli*-ийн халдвараас хамгаалах идэвхгүй дархлаа тогтоох өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *E.coli*-ийн эсрэг бием, фенол /C<sub>6</sub>H<sub>6</sub>O/ агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Улаавтар туяатай шаргал өнгийн шингэн. Энэхүү биобэлдмэлийг урт хугацааны турш хадгалахад цайвар саарал өнгөтэй ялимгүй тунадас үүсэж болох ба сэгсэрч зайлахад тунадас задарна.
- **Зориулалт:** Колибактериозын голомттой буюу уг халдварт өвчний гаралт тохиолдсон бүс нутагт байгаа мэдрэмтгий эрүүл буюу сэжигтэй мал амьтдад идэвхгүй дархлаа тогтоох болон *E.coli*-ийн халдвараар халдварласан төл малыг эмчлэх зориулалттай.
- **Эмчилгээ, сэргийлэлтэд хамрагдах амьтдын төрөл, нас, хүйс:** Төл малд хүйс харгалзахгүйгээр энэхүү ийлдсийн зохих тунг олгоно.
- **Тун:** Колибактериозын эсрэг ийлдсийг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх тохиолдолд тугал, унага, ботгонд 10-20 мл, хурга ишгэнд 5-7 мл-ийг, эмчилгээний зорилгоор хэрэглэх тохиолдолд тугал,

унага, ботгонд 20-30 мл, хурга ишгэнд 10 мл-ийг тус тус олгоно. Өвчилсөн төлийн эдгэрэлтийн байдлаас хамаарч эмчлэх тунг 2-3 удаа давтан олгож болно. Давтан олголтын хоорондын зай нь 8-16 цаг байна.

- **Олгох зам:** Хүзүүний арьсан дор тарьж олгоно.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй. Энэхүү эсрэг ийлдсийг мал амьтдад тарьж олгох, ялангуяа давтан тарих үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсэх магадлалтай.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хэт мэдрэгжил:** Мал, амьтдад ийлдсийг анх удаа буюу давтан тарьж олгох үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсч болно. Энэ урвал нь голомтолсон хэсэг газрын буюу бие махбодыг бүхэлд нь хамарсан ерөнхий хэлбэрээр илэрч болно.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү ийлдсийг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 36 сар хүртэл хүчинтэй.



# 24 ЭНТЕРОБАКТЕРИОЗЫН ЭСРЭГ ИЙЛДЭС

- **Олон улсын нэр:** ENTEROBACTERIOSIS SERUM

- **Тодорхойлолт:** Энтеробактериозын эсрэг ийлдэс нь энэхүү халдварт өвчний үүсгэгч *Escherichia coli*-ийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй нутгийн омгуудын өсгөврөөр бүтээхүүн малд хэт дархлаа хийж, цусан дах эсрэг биенийн төвшрүүлэг зохих хэмжээнд хүрэхэд цус авч, ийлдсийг нь ялган, хадгалааслаж бэлтгэсэн *E.coli*-ийн халдвараас хамгаалах идэвхгүй дархлаа тогтоох өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.

- **Найрлага:** *E.coli*-ийн нутгийн омгуудын эсрэг бием, фенол /C<sub>6</sub>H<sub>6</sub>O/ агуулна.

- **Гадаад байдал, хэлбэр:** Улаавтар туяатай шаргал өнгийн шингэн. Энэхүү биобэлдмэлийг урт хугацааны турш хадгалахад доод хэсэгт нь цайвар саарал өнгөтэй ялимгүй тунадас тунаж болох ба сэгсэрч зайлахад тунадас амархан задарна.

- **Зориулалт:** Энтеробактериозын голомттой буюу уг халдварт өвчний гаралт тохиолдсон бүс нутагт байгаа мэдрэмтгий эрүүл буюу сэжигтэй мал амьтдад идэвхгүй дархлаа олгох болон *E.coli*-ийн халдвараар халдварласан төл малыг эмчлэх зориулалттай.

- **Эмчилгээ, сэргийлэлтэд хамрагдах амьтдын төрөл, нас, хүйс:** Хонь, ямаанд нас, хүйс үл харгалзан сэргийлэх ба эмчлэх тунгаар олгоно.

- **Тун:** Энтеробактериозын эсрэг ийлдсийг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх тохиолдолд хонь, ямаанд 15-20 мл, хурга ишгэнд 10-15 мл-ийг, эмчилгээний зорилгоор хэрэглэх тохиолдолд хонь,

ямаанд 25-40 мл, хурга ишгэнд 20-30 мл-ийг тус тус олгоно. Өвчилсөн малын эдгэрэлтийн байдлаас хамаарч эмчлэх тунг 2-3 удаа 24-72 цагийн зайтай давтан олгож болно.

- **Олгох зам:** Хүзүүний арьсан дор тарьж олгоно.

- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй. Энэхүү эсрэг ийлдсийг мал амьтдад тарьж олгох, ялангуяа давтан тарих үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсэх магадлалтай.

- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.

- **Хэт мэдрэгжил:** Мал, амьтдад энтеробактериозын эсрэг ийлдсийг анх удаа буюу давтан тарьж олгох үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсч болно. Энэ урвал нь голомтолсон хэсэг газрын буюу бие махбодыг бүхэлд нь хамарсан ерөнхий хэлбэрээр илэрч болно.

- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** Энэхүү ийлдсийг +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 36 сар хүртэл хүчинтэй.



# 25 ДОТРЫН ХАЛДВАРТ ХОРДЛОГЫН ЭСРЭГ ИЙЛДЭС

- **Олон улсын нэр:** ENTEROTOXAEMIA SERUM

- **Тодорхойлолт:** Дотрын халдварт хордлогын эсрэг ийлдэс нь энэхүү халдварт өвчний үүсгэгч *Clostridium perfringens*-ийн C, D хэвшлийн хэвшлийн дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудын өсгөврөөр бүтээхүүн малд хэт дархлаа хийж, цусан дах эсрэг биемийн төвшрүүлэг зохих хэмжээнд хүрэхэд цус авч, ийлдсийг нь ялган, хадгалааслаж бэлтгэдэг *Clostridium perfringens*-ийн халдвараас хамгаалах идэвхгүй дархлаа тогтоох өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.

- **Найрлага:** *Cl.perfringens*-ийн C, D хэвшлийн нутгийн омгуудын эсрэг бием, фенол /C<sub>6</sub>H<sub>6</sub>O/ агуулна.

- **Гадаад байдал, хэлбэр:** Улаавтар туяатай шаргал өнгийн шингэн. Энэхүү биобэлдмэлийг урт хугацааны турш хадгалахад цайвар саарал өнгөтэй ялимгүй тунадас тунаж болох ба сэгсэрч зайлахад тунадас амархан задарна.

- **Зориулалт:** Дотрын халдварт хордлого өвчний голомттой, уг халдварт өвчний гаралт тохиолдсон бүс нутагт байгаа мэдрэмтгий эрүүл буюу сэжигтэй мал амьтдад идэвхгүй дархлаа олгох болон өвчилсөн малыг эмчлэх зориулалттай .

- **Эмчилгээ, сэргийлэлтэд хамрагдах амьтдын төрөл, нас, хүйс:** Хонинд нас, хүйс үл харгалзан сэргийлэх болон эмчлэх тунг олгоно.

- **Тун:** Дотрын халдварт хордлогын эсрэг ийлдсийг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх тохиолдолд хонинд 15-20 мл, хурганд 10 мл-ийг, эмчилгээний

зорилгоор хэрэглэх тохиолдолд хонинд 30-40 мл, хурганд 10-20 мл-ийг тус тус олгоно. Өвчилсөн малын эдгэрэлтийн байдлаас хамаарч эмчлэх тунг 2-3 удаа 24-72 цагийн зайтай давтан олгож болно.

- **Олгох зам:** Хүзүүний арьсан дор тарьж олгоно.

- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй. Энэхүү эсрэг ийлдсийг мал амьтдад тарьж олгох, ялангуяа давтан тарих үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсэх магадлалтай.

- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.

- **Хэт мэдрэгжил:** Мал, амьтдад дотрын халдварт хордлогын эсрэг ийлдсийг анх удаа буюу давтан тарьж олгох үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсч болно. Энэ урвал нь голомтолсон хэсэг газрын буюу бие махбодыг бүхэлд нь хамарсан ерөнхий хэлбэрээр илэрч болно.

- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:** +4°C-аас +10°C-ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар хүртэл хүчинтэй.



# 26 ЦУСАН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ИЙЛДЭС

- **Олон улсын нэр:** PASTEURELLOSIS SERUM
- **Тодорхойлолт:** Цусан халдварын эсрэг ийлдэс нь энэхүү халдварт өвчний үүсгэгч *Pasteurella multocida*-ийн эсрэгтөрүүлэгч чанар өндөртэй, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгуудын өсгөврөөр бүтээхүүн малд хэт дархлаа хийж, цусан дах эсрэг биемийн төвшрүүлэг зохих хэмжээнд хүрэхэд цус авч, ийлдсийг нь ялган, хадгалааслаж бэлтгэсэн *Pas.multocida*-ийн халдвараас хамгаалах идэвхгүй дархлаа тогтоох өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Pas.multocida*-ийн омгуудын эсрэг бием, фенол  $C_6H_6O$ / агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Улаавтар туяатай шаргал өнгийн шингэн. Энэхүү бэлдмэлийг урт хугацааны турш хадгалахад цайвар саарал өнгөтэй ялимгүй тунадас тунаж болох ба сэгсэрч зайлахад тунадас амархан задарна.
- **Зориулалт:** Цусан халдвар өвчний голомттой буюу уг халдварт өвчний гаралт тохиолдсон бүс нутагт байгаа мэдрэмтгий эрүүл буюу сэжигтэй мал амьтдад идэвхгүй дархлаа тогтоох болон *Pas.multocida*-ийн халдвараар халдварласан малыг эмчлэх зориулалттай.
- **Эмчилгээ, сэргийлэлтэд хамрагдах амьтдын төрөл, нас, хүйс:** Үхэр, хонь, ямаанд нас, хүйс үл харгалзан сэргийлэх болон эмчлэх тунг олгоно.
- **Тун:** Цусан халдварын эсрэг ийлдсийг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх тохиолдолд үхэрт 40-50 мл, хонь, ямаа, тугалд 20-30 мл-ийг, эмчилгээний

зорилгоор хэрэглэх тохиолдолд үхэрт 80-150 мл, хонь, ямаа, тугалд 30-60 мл-ийг тус тус олгоно. Өвчилсэн малын эдгэрэлтийн байдлаас хамаарч эмчлэх тунг 2-3 удаа 8-24 цагийн зайтай давтан олгож болно.


- **Олгох зам:** Хүзүүний арьсан дор тарьж олгоно.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, мал амьтанд аюулгүй. Энэхүү эсрэг ийлдсийг мал амьтдад тарьж олгох, ялангуяа давтан тарих үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсэх магадлалтай.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хэт мэдрэгжил:** Мал, амьтдад цусан халдварын эсрэг ийлдсийг анх удаа буюу давтан тарьж олгох үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсч болно. Энэ урвал нь голомтолсон хэсэг газрын буюу бие махбодыг бүхэлд нь хамарсан ерөнхий хэлбэрээр илэрч болно.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:**  $+4^{\circ}\text{C}$ -аас  $+10^{\circ}\text{C}$ -ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар хүртэл хүчинтэй.



- **Олон улсын нэр:** ANTHRAX SERUM
- **Тодорхойлолт:** Боомын эсрэг ийлдэс нь энэхүү халдварт өвчний үүсгэгч *Bacillus anthracis*-ийн эсрэгтөрүүлэгч чанар өндөртэй, дархлаа төрүүлэх өндөр идэвхтэй омгийн өсгөврөөр бүтээхүүн малд хэт дархлаа хийж, цусан дах эсрэг биемийн төвшрүүлэг зохих хэмжээнд хүрэхэд цус авч, ийлдсийг нь ялган, хадгалааслаж бэлтгэсэн *Bac. anthracis*-ийн халдвараас хамгаалах идэвхгүй дархлаа тогтоох өвөрмөц үйлчлэл бүхий биобэлдмэл юм.
- **Найрлага:** *Bac. anthracis*-ийн омгуудын эсрэг бием, фенол  $C_6H_6O$ / агуулна.
- **Гадаад байдал, хэлбэр:** Улаавтар туяатай шаргал өнгийн шингэн. Энэхүү бэлдмэлийг урт хугацааны турш хадгалахад цайвар саарал өнгөтэй ялимгүй тунадас тунаж болох ба сэгсэрч зайлахад тунадас амархан задарна.
- **Зориулалт:** Боом өвчний голомттой буюу уг халдварт өвчний гаралт тохиолдсон бүс нутагт байгаа мэдрэмтгий эрүүл буюу сэжигтэй мал амьтдад идэвхгүй дархлаа тогтоох болон *Bac. anthracis*-ийн халдвараар халдварласан малыг эмчлэх зориулалттай .
- **Эмчилгээ, сэргийлэлтэд хамрагдах амьтдын төрөл, нас, хүйс:** Бод болон бог мал, гахайд нас, хүйс үл харгалзан сэргийлэх ба эмчлэх тунгаар олгоно.
- **Тун:** Боомын эсрэг ийлдсийг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх тохиолдолд бод малд 10-20 мл, бог мал, гахай, бодын төлд 5-10 мл-ийг, эмчилгээний зорилгоор хэрэглэх тохиолдолд бод малд 50-200 мл,

бог мал, гахай, бодын төлд 30-50 мл-ийг тус тус олгоно. Өвчилсөн малын эдгэрэлтийн байдлаас хамаарч эмчлэх тунг 2-3 удаа 8-24 цагийн зайтай давтан олгож болно.

- **Олгох зам:** Хүзүүний арьсан дор тарьж олгоно.
- **Аюулгүй чанар:** Хүрээлэн буй орчин, хүн, маламьтанд аюулгүй. Энэхүү ийлдсийг мал амьтдад тарьж олгох, ялангуяа давтан тарих үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсэх магадлалтай.
- **Гаж нөлөө:** Тэмдэглэгдээгүй.
- **Хэт мэдрэгжил:** Мал, амьтдад боомын эсрэг ийлдсийг анх удаа буюу давтан тарьж олгох үед огцом хэт мэдрэгжлийн урвал үүсч болно. Энэ урвал нь голомтолсон хэсэг газрын буюу бие махбодыг бүхэлд нь хамарсан ерөнхий хэлбэрээр илэрч болно.
- **Хадгалалт, хүчинтэй хугацаа:**  $+4^{\circ}C$ -аас  $+10^{\circ}C$ -ийн харанхуй, хуурай байранд хадгална. Ийм нөхцөлд хадгалахад үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар хүртэл хүчинтэй.





976-7049-2132



[Info@biocombinat.mn](mailto:Info@biocombinat.mn)



[www.biocombinat.mn](http://www.biocombinat.mn)



**БИОКОМБИНАТ ТӨХХК**  
Монгол улс Улаанбаатар хот-17140,  
Хан-Уул дүүрэг, 12-р хороо